



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙДЫН ТУШААЛ

2013 оны 03 сарын 29 өдөр

Дугаар 97

Улаанбаатар хот

Мэдээллийн шуурхай байдлыг
хангах тухай

“Эрүүл мэндийн удирдлагын мэдээллийн тогтолцоог хэрэгжүүлэх стратеги (2011-2015)”-ийг хэрэгжүүлэх, мэдээллийн бодит, шуурхай байдлыг хангах зорилгоор ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн байгуулагуудад бүртгэгдэж буй хүн амын төрөлт, нас баралт, эх, хүүхдийн эндэгдэл, амбулатори стационарын тусламж үйлчилгээний үзүүлэлтүүдийн талаарх эрүүл мэндийн албан ёсны статистикийн мэдээллийг сар бүрийн 2 дах долоо хоногийн Эрүүл мэндийн яамны Удирдлагын зөвлөлийн шуурхай хурлаар танилцуулахыг Эрүүл мэндийн хөгжлийн төв/Ч.Бат-Эрдэнэ/-д үүрэг болгосугай.

2. Эрүүл мэндийн байгууллага дээр гарч буй ололт амжилтыг хэвлэл мэдээллээр шуурхай мэдээлэх, эмнэлэгт бүртгэгдсэн алдаа зөрчлийн талаарх мэдээлэл гарсан тохиолдолд Эрүүл мэндийн хөгжлийн төвд шуурхай хангажажиллахыгбүх шатны эрүүл мэндийн байгууллагын дарга, захирал нарт үүрэг болгосугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн нарийн бичгийн дарга (Ж.Хатанбаатар)-д даалгасугай.

САЙД  Н.УДВАЛ

